

# ӨНДӨРХААН ХК

2023 оны 8 сарын 02-ны өдөр

№23/08

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, Өндөрхаан ХК-ийн “Дүрэм”-ийн 5.5 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын 2023 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн №02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өндөрхаан” ХК-ийн “Дүрэм”-ийн шинэчилсэн найруулгыг Хавсралтаар баталсугай.
2. “Дүрэм”-ийн шинэчилсэн найруулгыг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (О. Амарболд)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



ЦОГБАДРАХ

# ӨНДӨРХААН ХК

2023 оны 8 сарын 02-ны өдөр

№23/09

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Хувьцаа худалдан авах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, Өндөрхаан ХК-ийн “Дүрэм”-ийн 5.5 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын 2023 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн №02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ардын Тэтгэврийн Данс” ХХК-ийн нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 10,010,000 ширхэг энгийн хувьцааг 10,010,000,000 төгрөгөөр “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-иас Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний дагуу худалдан авахыг зөвшөөрсүгэй.
2. Хувьцааны нийт төлбөрийг төлөхтэй холбоотой өр төлбөр үүсгэж, “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-тай өр төлбөрийг хувьцаагаар хөрвүүлэх онцгой эрх олгох нөхцөл бүхий гэрээ байгуулах, гэрээний нөхцөлийг тохирох эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөл (Г. Цогбадрах)-д олгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл (Г. Цогбадрах)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Г. ЦОГБАДРАХ



# ӨНДӨРХААН ХК

2023 оны 8 сарын 02-ны өдөр

№23/10

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Хэлцэл батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, Өндөрхаан ХК-ийн “Дүрэм”-ийн 5.5 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын 2023 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн №02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-иас 15,000,000,000 (арван таван тэрбум) төгрөг хүртэлх хэмжээтэй, хувьцаанд хөрвөх онцгой эрх олгох нөхцөл бүхий санхүүжилт авахыг зөвшөөрсүгэй.
2. Санхүүжилтийг хувьцаа хэлбэрээр авах ба шилжүүлэн авах хувьцаа болон хувьцааны тоо ширхэг, үнэлгээг тогтоох эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөл (Г. Цогбадрах)-д олгосугай.
3. Санхүүжилтийг хувьцаа руу хөрвүүлэх нөхцөл болон бусад нөхцөлийг тохирох, энэ харилцаатай холбоотой гэрээ байгуулах эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөл (Г. Цогбадрах)-д олгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл (Г. Цогбадрах)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Г. ЦОГБАДРАХ

